

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-15
1. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	5-7
2. Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын болон холбогдох бусад Засгийн газрын гишүүдийн мэдээлэл сонсох	7-12
3. “Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	12-14
4. “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	14-15

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 22-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 52 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Лүндэг, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Уянга, М.Энхцэцэг;
Чөлөөтэй: П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Д.Жаргалсайхан, Г.Лувсанжамц.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Анар, мөн газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Өнөржаргал, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Үйлдвэр, технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Нэмэхбаяр, Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, “Эрдэнэс үйлдвэр технологийн парк” ХХК-ийн төсөл хөгжүүлэлтийн менежер Г.Ганхуяг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

С.Ганбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 3.3 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.23, ШСБ-3.4.1, ЗГҮАХ-3.3.4.15” гэж, Төсөл арга хэмжээ “3.3.1.5.Малын гаралтай түүхий эд, арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж” гэж, Шалгуур үзүүлэлт “Ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний экспортын өсөлт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “9,400.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилтийн хэмжээ “5,400.00” гэж, Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэсэн 3.3.1.5 дахь дэд заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	8
Бүгд:	13

38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын болон холбогдох бусад Засгийн газрын гишүүдийн мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Анар, Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, ахлах мэргэжилтэн Л.Элбэгзаяа, Б.Баттуяа, Э.Бүжинлхам, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Эдийн засаг, хөгжлийн яамны мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө

оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Анар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны мэдээллийг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Эдийн засаг, хөгжлийн яам болон бусад яамны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл үг хэлэв.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	4
Бүгд:	14

71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Б.Тулга нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга С.Ганбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 23 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 60.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 09 цаг 52 минут

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Далайн Батбаяр гишүүн ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Хажикберын Жангабыл гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн ирсэн байна. Ингээд ирц 52,2 хувьтайгаар өнөөдрийн 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газрын 2025 оны 4 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

2 дугаар хэлэлцэх асуудал байна. Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд болон холбогдох бусад Засгийн газрын гишүүдийн мэдээллийг сонсох.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

4.Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” гэсэн ийм 4 хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Санал байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дүгээр хэлэлцэх асуудал.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэх үйл ажиллагааг явуулъя.

Ингээд ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны газрын дарга байна. Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирсэн байна. Анар Эдийн засаг,

хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Өнөржаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга байна. Өнөржаргал ирсэн байна. Балчинлуvsан Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалт газрын дарга, Мөнгөсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын дарга, Мөнхтөр Эдийн засгийн хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн дарга, Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн ирчихсэн байна уу. Босоорой. Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Хонгор Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Бодлогын газрын дарга ирсэн байна. Нэмэхбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Үйлдвэр технологийн бодлогын хэлтсийн газрын дарга ирсэн байна. Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга ирсэн байна. Ганхуяг “Эрдэнэс үйлдвэр технологийн парк” төсөл хөгжүүлэлтийн менежер ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга ирсэн байна. Ингээд албаны хүмүүсээ танилцууллаа.

“Монгол Улсын хөгжлийн 2026 онд төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Мөнхбаясгалан гишүүн байгаа юм байна. Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. Ингээд Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

Ингээд саналаа би та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос ирүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 3.3 дахь заалтын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлсэн байна.” гэж, Хөтөлбөрийн үр дүн “Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн байна.” гэж, Бодлогын үндэслэл “АХ-4.2.23, ШСБ-3.4.1, ЗГҮАХ-3.3.4.15” гэж, Төсөл арга хэмжээ “3.3.1.5.Малын гаралтай түүхий эд, арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж” гэж, Шалгуур үзүүлэлт “Ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний экспортын өсөлт” гэж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь түвшинд “0” гэж, Зорилтот түвшин “100” гэж, Нийт санхүүжилтийн дүн “9,400.00” гэж, Тухайн жилд шаардагдах санхүүжилтийн хэмжээ “5,400.00” гэж,

Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал “Улсын төсөв” гэж, Үндсэн хариуцагч “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэсэн 3.3.1.5 дахь дэд заалт нэмэх гэсэн ийм санал гаргасан байна. Ингээд саналтай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу. Кнопоо дараарай. Батлут гишүүн асуулт асууя.

Дэгээрээ асуулт асуухгүй юм байна шүү. Дэмжих, дэмжихгүй гэдэг санал шууд хураагаад явах юм байна шүү. Батлут гишүүн ээ. Тэгэхээр дэмжинэ, дэмжихгүй гэдгээр та нар маань эрхээ эдэлнэ. Тэгэхдээ энэ дээр бол дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явагдаж байгаа юм байна шүү. Ингээд Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Лутаа дарга ойлголоо. Энийг ямар ч байсан саналаа явуулаад Эдийн засгийн байнгын хороон дээр 3 цагаас бас энийгээ ярилцах юм байна шүү. Дахиад чуулганаар ч гэсэн ярилцана. Ингээд гишүүд бол саналуудаа хураачихлаа.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Ингээд тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц Эдийн засгийн байнгын хороонд танилцуулна.

10.00 цаг

Хэлэлцэх асуудлын 2. Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон холбогдох бусад Засгийн газрын гишүүдийн мэдээллийг сонсох гэсэн хэлэлцэх асуудал руугаа оръё.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Оюунгэрэл Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Элбэгзаяа Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдаа нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Баттуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн газрын ахлах мэргэжилтэн, Бүжинлхам Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хөгжлийн хэлтсийн зөвлөх. Мөнхтүшиг Гадаад харилцаа яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга гэсэн ийм албаны хүмүүс оролцсон байна.

Дээрх мэдээллийг холбогдох албан тушаалтнууд товч мэдээллээ өгнө үү. Эхлээд Эдийн засгийн яамнаас эхэлье. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэддүгээр микрофон дээр байна. 3 дугаар микрофон дээр мэдээллээ өгье. Дараа нь 6 дугаар микрофон, дараа нь 9 дүгээр микрофон байна. 3 дугаар микрофон нээчихсэн байна.

Б.Анар: Байнгын хорооны дарга болон эрхэм гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Эдийн засаг, хөгжлийн яам Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Анар. Ирүүлсэн асуудалтай холбоотойгоор товчхон танилцуулга хийе.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Оросын Холбооны улстай байгуулсан хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн чиглэлийн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар товчхон танилцуулъя.

Юуны өмнө тус яам нь БНХАУ-ын Худалдааны яам болон Үндэсний хөгжил шинэтгэлийн хороотой хамтран худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны хөгжлийн хөтөлбөр гэх 2 томоохон бодлогын баримт бичгийг бол байгуулан хэрэгжилтийг нь бас хангуулах чиглэлээр ажилладаг. Эдгээр хөтөлбөрийн хүрээнд ногоон хөгжил, цахим эдийн засаг, хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, цөлжилттэй тэмцэх зэрэг нийтдээ салбаруудыг хамарсан 7 санамж бичиг бол харилцан байгуулж, хамтын ажиллагааг бол идэвхтэй өрнүүлж байна.

Мөн Монгол, Орос, Хятадын 3 талт хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төсөл арга хэмжээний жагсаалтыг бол одоогийн байдлаар талууд эцэслэн тохиролцоод, хэрэгжилтийг эрчимжүүлэхээр бол хамтран ажиллаад явж байна.

Бүс нутгийн болон хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр бол дараах ажлуудыг хийж байна. Энэ дотор бол Монгол Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбооны хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн яриа хэлэлцээг бол үргэлжлүүлээд хийгээд явж байна. Энэ хэлэлцээрийн хүрээнд нийтдээ 367 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнүүдийг харилцан импортын гаалийн татварыг тэглэх бол ийм хэлэлцээр бол байгаа. Хэлэлцээрүүдийг бол эхний шатад тохирсон хэлэлцээрийн төслүүдийг бол холбогдох Байнгын хороотой зөвшилцөөд дууссан. Одоо айлын талтай ёсчлон албажуулах ажил хүлээгдэж байна. Үүний дараагаар бол Улсын Их Хурал руу оруулж, танилцуулж соёрхон батлах ийм ажил бол хийгдэнэ. Мөн үүнээс гадна 2 талын худалдаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бизнесийн шинэ боломжийг бий болгох зорилгын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн 4 шатны хэлэлцээг бол амжилттай зохион байгуулсан байгаа.

Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хайнань мужийн Бау хотноо болдог Баугийн Азийн эдийн засгийн чуулга уулзалтад бол тус яам төлөөлөөд, хөрөнгө оруулалт, худалдаа, өндөр технологийн чиглэлээр бол хамтран ажиллах талаар бол БНХАУ-ын талтай бол хамтын ажиллагааг үргэлжлүүлээд явж байна.

Аж үйлдвэр, хилийн боомт, гааль, татвар, зам тээвэр, эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд та бүхэн мэдэж байгаа сая Гашуунсухайт-Ганцмод төмөр замын бүтээн байгуулалтын ажлын нээлт бол энэ оны 5 сарын 14-ний нээлт бол болсон. Ханги-Мандал, Шивээхүрэн-

Сэхээ, Бичигт-Зүүн хатавч боомтын төмөр замын холболтыг эхлүүлэх чиглэлээр бол айлын талтай байнгын бүхий л түвшинд яриа хэлэлцээрүүд бол хийгдээд явж байгаа.

Орос, Монголын бүс нутгийн форумыг бол энэ оны 10 дугаар сард Эрхүү хотод зохион байгуулахаар төлөвлөсөн ажиллаж байгаа. Мөн энэ оны 6 сарын сүүлээр ЕАЭЗХ-ны гишүүн улсуудтай хамтарсан цаашдаа худалдааны хэлэлцээр байгуулагдах юм бол хэрхэн энэ хэлэлцээрийн үр ашгийг дээшлүүлэх вэ гэсэн дугуй ширээний ярилцлага уулзалтыг бол Беларусь Улсын Миск хотод бас хийхээр төлөвлөөд ажиллаж байна. Эцэст нь хэлэхэд гадаад худалдааны үйл ажиллагааг цахимжуулах үр ашигтай нээлттэй болгох үүднээс гадаад худалдааны цахим нэг цонхны мэдээллийн системийг бол хөгжүүлэлт хийгдээд явж байгаа. Энэ дотор бол худалдаанд оролцогч бүхий л талуудын мэдээллийг нэгтгэх, дээрээс нь төрийн байгууллагуудаас олгож байгаа төрөл бүрийн зөвшөөрлүүдийг бол нэг дор нэгтгэсэн ийм цахим системийн хөгжүүлэлтийг хийхээр ажиллаад явж байна. Товчхон мэдээлэл өгч дууслаа.

С.Ганбаатар: Баярлалаа. 6 дугаар микрофон дээр мэдээлэл өгье. Дараа нь 9 дүгээр микрофон бэлдээрэй.

Т.Жамбалцэрэн: Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Байнгын хорооны дарга, гишүүдэд салбарын чиглэлээр мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар хүргүүлсэн учраас товчхон мэдээллийг өгье.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээг авч байгаа үйл ажиллагааныхаа талаар товчхон мэдээллийг танилцуулъя.

Монгол, Хятадын 2 талт хамтын ажиллагааг эрчимжүүлэх, мал, амьтан, ургамал, хорио цээрийн протоколыг шинэчлэх болон шинээр байгуулах. БНХАУ-тай хил дамнасан аймгуудын боомтууд, үүн дотроо Баянхошуу, Хавирга, Бичигт, Булган, Бургастайгаар дамжуулан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт, хорио цээрийн байгууллагын лабораторийн багтаамж чадавхыг дээшлүүлэх замаар экспорт хийх боломжтой боомтын тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад адуу, үхэр, хонь, ямааны дайвар бүтээгдэхүүн экспортлох үеийн мал, эмнэлэг, хорио цээрийн протоколыг Монгол Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хооронд протокол байгуулж, мал амьтны дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлэх замаар мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 248 дугаар тогтоолоор Ургамал хамгааллын газрыг шинээр байгуулсан бөгөөд хөрш орнуудад экспортлох ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх экспортлох үеийн хорио цээрийн протоколыг харилцан тохиролцож байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж, холбогдох саналыг айлын талд хүргүүлээд байна.

Мөн хөнгөн үйлдвэрийн салбарт экстелийн тогтвортой үйлдвэрлэл үндэсний стандартыг хангасан ноос ноолуур үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын экспортлох үеийн шаардагдах үйлдвэрлэлийн баталгаажуулалтаар харилцан тохирох протоколыг байгуулахаар бас холбогдох саналыг айлын талд хүргүүлж байна.

Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн хүрээнд мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуурын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, түүнчлэн хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг импортлоход дэмжлэг үзүүлэх зэрэг саналыг боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар Оросын Холбооны Улсын бүх холбоотын Мал, амьтан, ургамал, хорио цээрийн хяналтын албаны харьяа Холбооны Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах төвөөс жил бүр 10-12 сая тун шүлхийн болон үхрийн арьс товруутах өвчний эсрэг вакциныг арилжааны шугамаар худалдан авч байгаа бөгөөд 2025 онд 14 сая тун вакцин худалдан авахаар төлөвлөж холбогдох гэрээ хэлэлцээрийг хийгээд байна.

Монгол Улсын мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах замаар хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардагдах махны хангамжийн эх үүсвэрийг бий болгох, бүс нутгийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Монгол малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийн 3 дугаар үе шатыг Оросын Холбооны Улстай хамтран хэрэгжүүлэх талаар холбогдох саналыг боловсруулж, ойрын хугацаанд 2 хөршид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байгаа болно.

Салбарын хийгдэж байгаа ажиллагааг товч танилцууллаа. Дэлгэрэнгүй мэдээллийг гишүүдэд хүргүүлсэн болно. Баярлалаа.

С.Ганбаатар: Баярлалаа. Би түрүүн бас протоколд анхааруулж 1 дүгээр хэлэлцэх асуудал дээр түрүүн Бямбацогт гишүүний саналыг 38,5 хувийн хувьтайгаар дэмжигдээгүй юм байна шүү гэдгийг протоколд бас тусгах ёстой юм байна. Энийгээ хэллээ.

Ингээд одоо Сангийн яамны мэдээллийг 9 номерын микрофон дээр өгнө үү. Ер нь бол хил боомт энэ гаалийн асуудал дээр бол Тулга сайдын удирдаж зохион байгуулсны үр дүнд маш олон үр дүнгүүд гарч байгаа. Яамнууд дээр ч гэсэндээ энэ дээр маш олон сайн үр дүнгүүд гарч байгаа. Энийг хоорондын уялдааг хангая. Аж үйлдвэрийн бодлогын байнгын хороо бас цэгцтэйгээр яаж эрх зүйн талаас нь дэмжих вэ гэдгээр өнөөдрийн энэ мэдээллийг авч байгаа. Дараа нь ажлын хэсгүүдээ бас байгуулах учиртай юм. Ингээд Сангийн яам мэдээллээ өгнө үү.

Ж.Дэлгэржаргал: Байнгын хорооны дарга, байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аж үйлдвэрийн байнгын хорооноос ирсэн албан бичгийн дагуу 3 чиглэлээр мэдээллийг бэлтгэж, дэлгэрэнгүй байдлаар Байнгын хороонд хүргүүлсэн байгаа учраас товчхон мэдээллийг танилцуулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал.

Эхний асуудал Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Оросын Холбооны Улстай байгуулсан Эдийн засаг, худалдаа хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн талаар товч мэдээлэл байгаа. Энд бол Оросын Холбооны Улстай одоогоор байгуулсан хөнгөлөлттэй зээл, тусламжийн төсөл байхгүй байгаа. Дээрээс нь Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 2015 онд 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулсан. Энэ зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хийгдэж байгаа төслүүд, үүний үр дүнд гарсан мэдээллүүдийг бэлтгэж хүргүүлсэн байгаа.

2 дахь асуудал бол бүс нутгийн болон хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа. Энэ дээр бол Засгийн газар бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил дамнасан худалдааг хөнгөвчлөх, дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай хийгдэж байгаа. Нийтдээ 665.1 тэрбум төгрөгийн 4 төслийг хэрэгжүүлж байгаа. Азийн хөгжлийн банкны 4 төслөөр ялангуяа боомтуудын бүтээн байгуулалт, өргөтгөл шинэчлэлтэй холбоотой мэдээллүүдийг бэлтгэсэн.

3 дугаар асуудал бол аж үйлдвэр, хилийн боомт, гааль, татвар, зам тээвэр, эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг шинэ түвшинд хөгжүүлэх асуудал дээр мөн хэрэгжүүлж байгаа бодлогууд. Энэ дээр боомтын сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төслүүд эрчим хүчний сэргэлтийн хүрээнд ялангуяа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр ирж байгаа Эрдэнэбүрэн УЦС-ын төсөл, аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд бол газрын тос боловсруулах үйлдвэр гээд үүнтэй холбоотой мэдээллүүдийг бэлтгэх сан байгаа. Мөн татварын бодлогын хүрээнд яг энэ хил орчмын худалдааг хөгжүүлэх дээр татварын бодлогоор хэрэгжүүлж байгаа борлуулалтын орлогын 1 хувь хүртэлх дүнгээр татварын хөнгөлөлт эдлэх энэ боломжийн талаар бас мэдээллүүдийг бэлтгэж дэлгэрэнгүй мэдээллээр Байнгын хороонд хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Яамнууд хариуцлагатай бас дэлгэрэнгүй мэдээллүүдээ цаасаар ирүүлсэн байна. Гишүүдэд бас тараасан байгаа. Ингээд мэдээлэл авч дууслаа. Гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Гишүүд нэрсээ өгнө үү. Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Би санал хэлчихье. Асуулт гэхээс илүү. Яах вэ өнөөдөр бол бид нар бас энэ 2 хөрш оронтойгоо хэрхэн эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр хийсэн гэрээ хэлцлийн хэрэгжилт, үр дүн ямар байгаа юм бэ гэдгийг бодлогын гол яамнууд бас гүйцэтгэлээ тайлагнаж байна гэж ойлгож байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам. 3 ирсэн материал дотор Сангийн яамны мэдээлэл их ойлгомжтой байна. Ойлгомжтой байна. Хөтөлбөрт орсон, хэлэлцээрт орсон асуудлуудын гүйцэтгэл юу нь биелсэн юм, юу нь биелээгүй байна, шалтгаан нь юу юм гээд. Тэгээд энэ дээр бол бид нар бас Байнгын хорооны гишүүд хараад үнэлэлт, дүгнэлт өгөх боломж байна гэж харж байгаа. Нөгөө 2 яамны хувьд бол би хэлж мэдэхгүй байна. Ингэж сонсох хэрэг байсан ч юм уу, үгүй ч юм уу. Хэчнээн гэрээ хэлцэл аль улстай, Хятад улстай хийсэн ямар гэрээ хэлцлийнх нь хэдэн заалт нь хэрэгжихгүй байгаа. Тэрний шалтгаан нөхцөл нь юу юм. Баахан тоо тавьчихсан л байна л даа. Тэрийгээ задлаад энэ чинь гүйцэтгэл гаргаж байгаа юм бол ямар ажлуудыг хоорондоо хийнэ гэж харилцан тохиролцчихоод, юу нь хэрэгжээд, юу нь хэрэгжихгүй байгаад байгаа

юм. Үгүй ээ, бид нар чинь ерөнхий мэдээлэл, тоо аваад тэгээд энэ дээр ямар дэмжлэг үзүүлэх вэ ер нь. Уг нь бол манай Байнгын хорооны даргын түрүүн танилцуулснаар энэ ажлыг бас парламентын зүгээс эрчимжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх чиглэлээр мэдээллийг сонсож байна гэж би ойлгож байгаа.

Тэгээд одоо бол энэ дээр надад ямар ч хэлэх коммент алга. Яагаад гэвэл ийм хэмжээний мэдээлэл дээр бид нар яаж ажиллах юм. Тэгээд ер нь манай яамнууд Байнгын хороо дээр асуудал оруулахаар энэ мэдээлэл өгдөг арга барилаа жоохон өөрчилмөөр байна. Хайгаад олоод аваарай гэсэн шиг л материал явуулах юм. Тэгээд ийм материал дээр гишүүд цаг заваа барж, Байнгын хорооны хурал хийх гэж энд бас бид нар чинь нэгдсэн чуулгандаа ч орж чадахгүй сууж байна шүү дээ. Ингэж цаг үрмээргүй байна. Яг үнэнийг хэлэхэд. Энэ дээр би ажлын хэсэг цааш нь байгуулаад ажиллах хэрэгцээ байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг ч олж харж чадахгүй байна. Яг үнэнийг хэлэхэд. Эдийн засаг, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам. Одоо Эдийн засаг, хөгжлийн яамныхан уучлаарай би бараг л Байнгын хорооны хурал болгон дээр л Эдийн засаг, хөгжлийн яаманд коммент хэлдэг боллоо. Үнэхээр болохгүй байна. Яаж явах юм бэ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлоод байгаа газар яаж явах юм цаашдаа. Тэгээд энэ дээр бас анхаарч ажиллах нь зүйтэй байх. Байнгын хороон дээр ч гэсэн ирж байгаа материалууд дээр жоохон шалгуур тавьж хүлээж авах, буцаах энэ тэр юман дээр Байнгын хорооны ажлын албаныхан маань ажилладаг байх нь зөв болов уу гэж бодож байна.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн санал хэллээ. Ингээд хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр бодит байдал ийм л байгаа. Яамнууд дээр яг нарийн яривал Хил боомтын асуудал хариуцсан үндэсний хороо нь байдаг тэнхээгээрээ л ажиллаад байгаа шүү дээ. Яамнууд дээр ч гэсэн олон зүйлүүд байгаа. Энийгээ дэлгэрүүлж тайлбарлаж, бас үүсэж байгаа бэрхшээлүүдээ яаж гарц гаргалгаатай шийдэх вэ гэдэг шийдлүүдээ ярихгүй байна гэдэг бол бидний бас том алдаа шүү. Тэгээд энийг эрчимжүүлэх, энийг уялдааг нь сайжруулъя гэж өнөөдөр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо мэдээлэл сонсож байгаа. Бас ажлын хэсэг гаргахгүй бол бахь байдгаараа л байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэллээ.

Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэр, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болон холбогдох бусад Засгийн газрын гишүүдийн мэдээллийг хэлэлцэж дууслаа.

10.18 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудлын 3.

**“Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай”
Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар Засгийн газрын гишүүдийн мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд

холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, удирдамжийг батлах Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

“Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай” тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Ингээд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ажлын хэсэг байгуулах, үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Энэ ажлын хэсгийг бол Тулга сайдтай нэлээн зөвлөлдөж ярьсан байгаа. Маш олон ажлууд хийгдсэн. Маш олон чамбай чамбай гарц гаргалгаанууд гаргачхаад бусад яамнуудын уялдаа холбоог нь сайжруулахгүй бол хайран хийсэн ажлуудыг бас аж үйлдвэржилтийн хөгжилд эрчимжилтэд нь саад болж байна гэж бид үзэж энэ ажлын хэсгээ байгуулж байгаа юм шүү. Тэгээд өнөөдөр ер нь хил орчмын худалдаагаа л өргөжүүлж сайжруулахгүй бол юун цаашаа далай гаталж алгасаж хил наймаа хийх вэ дээ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.Хил орчмын худалдаа, бүс нутгийн аж үйлдвэржилтийн өсөлт, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, үйл ажиллагааг эрчимжүүлэх бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч С.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга. Гишүүд Бадамсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Ганзориг Улсын Их Хурлын гишүүн, Жаргалсайхан Улсын Их Хурлын гишүүн, Тулга Улсын Их Хурлын гишүүн, сайд.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийн хавсралтаар баталсугай. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор холбогдох байгууллагаас эрх бүхий албан тушаалтныг оролцуулж, ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

4.Ажлын хэсгийн санал, дүгнэлт, холбогдох шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, хэлэлцүүлэх. Тогтоолын биелэлтийг Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу. Жангабыл гишүүнээр тасаллаа. Жангабыл гишүүн асуулт асууж, үг хэлнэ үү.

Х.Жангабыл: Баярлалаа. Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Би энэ ажлын хэсэгт ажиллах саналтай байна. Яагаад гэхээр Баян-Өлгий аймагт БНХАУ болон ОХУ-тай хиллэдэг боомттой. Тэгэхээр энэ ажлын хэсэгт орж ажиллахыг хүсэж байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Жангабыл гишүүний саналыг хүлээж авлаа. Ингээд тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Улайчихлаа гээд байна. Ингээд дэмжигдсэн байна. Тулга сайд дэмжиж байгаа. Далайн Батбаяр гишүүн дэмжиж байгаа. Ингээд гишүүд дэмжлээ. Гишүүд маань бас зөвөөр ойлгоорой. Дараа нь 10 цагаас Эмэгтэйчүүдийн хурал болно гээд цаг авчихсан байгаа учраас хүлээлгээд сандраад байгаа шүү.

10.22 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе. **“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан дээрх мега төслүүдийн хэрэгжилтийн явцыг шалгаж судлах, үйл ажиллагааг эрчимжүүлэх бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 9 дүгээр тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор байгуулагдсан мега төслүүдийн хэрэгжилтийн явцыг шалган судлах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтааж Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх ажлын хэсэг Д.Үүрийнтуяа-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатарт даалгасугай.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм удирд баталж байна. Ингээд удирдамжийн төслийг тараасан байгаа. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Золжаргал гишүүнээр тасаллаа. Ингээд Золжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Золжаргал: Ажлын хэсэгт орох саналыг одоо хүлээж авах боломжтой юу. Тусдаа тусдаа дэгээр явах юм уу.

С.Ганбаатар: Золжаргал гишүүн ээ, дараагийн хуралдаанаар энэ дээр бүр дахиад хүсэлтээ та бичгээр өгчхөөрэй. Тэгээд дараагийн хуралдаанаар хэлэлцье. Ингээд ажлын хэсгийн удирдамжийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. 12 гишүүн буюу 85,7 хувийн саналаар дэмжигдлээ.

Тэгээд энэ дашрамд хэлэхэд мега төслүүд гээд л улс орон даяар ярьсаар байгаад, ярьсаар байгаад баталдаг. Тэгээд л мартаад, дараагийн том гоё сенсаций юмаа хүлээгээд байхын оронд байгаа мега төслөө хэрэгжүүлэхийн төлөө Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо бас нягталж ажиллана. Тэгээд, ажлын хэсгийн хамт олонд өндөр амжилт хүсье.

Ингээд өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархаж байна. Өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

10.25 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ